Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Боловсролын тухай

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 907129.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 18142.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 909854.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 18197.0 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 7199765.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 1525925.6 мянган төгрөгөөр буюу 26.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 29,214.1 | 42,140.2 | 12,926.1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 96.0 | 15,330.0 | 15,234.0 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 29,118.1 | 26,810.2 | (2,307.9) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 5,644,625.5 | 7,157,625.0 | 1,512,999.6 |
| Үндсэн хөрөнгө | 5,974,399.5 | 7,511,274.0 | 1,536,874.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (329,774.0) | (353,648.9) | (23,875.0) |
| **Нийт хөрөнгө** | 5,673,839.6 | 7,199,765.2 | 1,525,925.6 |
| Өр төлбөр | - | 33.5 | 33.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 5,673,839.6 | 7,199,738.9 | 1,525,899.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 5,673,839.6 | 7,199,772.4 | 1,525,932.8 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Өмнөх оны 96,0 мянган төгрөгийн авлагыг барагдуулж тайлант онд 15330,0 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн нь цахим фитнес теслийн тоног төхөөрөмж "Санко Маркетинг Монголиа" ХХК-аас "Ухаалаг самбар" 9990,0 мянга, "ОАЛ-селлер" ХХК-аас "Процессор МТ51-i5" 2410,0 мянга, "Хобби зоон" ХХК-аас "Гар утасны дүрс тогтворжуулагч" 480,0 мянган төгрөгөөр худалдан авахаар, авто машины бэхэлгээ, нум хийлгэхээр "Ерөөл нэмэх" ХХК-д 2450,0 мянган төгрөгийг тус тус шилжүүлснээс авлагын дансны үлдэгдэл өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 26810,1 мянган төгрөг болж 2307,9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийг зарцуулсан голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7511273,9 мянган төгрөг болж 1536874,5 мянган төгрөгөөр өссөн нь "Цэнгэлдэх, наадмын талбайн, Крекитийн талбай, 7 багийн заалны, газрыг 925700,0 мянга, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ирсэн UAZ- 220695 маркийн 49-98 БНА улсын дугаартай 33600,0 мянган төгрөгийн автомашин, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар засвар хийгдсэн 1-р багт байрлах хуучин заалны барилгын 486286,4 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтыг сайжруулалтаар, 4 дүгээр багийн спорт гадна дулааны шугам 110108,7 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн 33600,0 мянга, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 596395,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 1446078,0 мянган төгрөг болж 925700,0 мянган төгрөгөөр өссөн шинээр эзэмшилд бүртгэсэн 925700,0 мянган төгрөгийн газар нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 26,3 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын зардлыг дутуу шилжүүлснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7199738,9 мянган төгрөг болж 1525899,2 мянган төгрөгөөр өссөн нь 925700,0 мянган төгрөгийн газар, 2018 онд дахин үнэлгээнд хамруулаагүй хөрөнгийн дахин үнэлгээ 109156,5 мянга, тайлант үеийн үр дүн 491042,6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1400889,7 мянган төгрөг болж, өмнөх оноос 28705,2 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөв байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 198314,7 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, үндсэн үйл ажиллагааны орлого буурсантай, тусламж санхүүжилтийн орлого 169609,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 150202,6 мянган төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн дансанд орон сууцны хөнгөлөлт 5000,0 мянга, цахим фитнес төслийн санхүүжилт 13120,0 мянга, мэдээллийн цахим сан бүрдүүлэх 2000,0 мянган төгрөгийн санхүүжилт авсантай холбоотой байна.

Нийт зардал 909854,3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 139112,3 мянган төгрөгөөр буюу 18,0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ- 60361,1 мянга, халаалтын зардал 49152,9 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлийн зардал 4727,5 мянга, урсгал засварын зардал 6228,9 мянга, газрын төлбөр 5123,8 мянга, үндсэн хөрөнгийн элэгдэл 26321,3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 880726,1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 880726,1 мянган төгрөгөөр тооцон, ажиллагсдыг 30 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 83712,9 мянган төгрөгөөр бууруулж 797013,2 мянган төгрөгөөр, ажиллагсдыг 30 орон тоогоор баталж Цалин, НДШ, халаалт, тээвэр шатахуун, тавилга эд хогшлын, бараа үйлчилгээний бусад зардлыг бууруулж, урсгал засвар, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг нэмэгдүүлж баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**



065 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 770282,0 мянган төгрөгийн төсөв баталснаас 765228,2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5000,0 мянган төгрөгийг төсөвт байгууллын үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 765228,5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5915,5 мянган төгрөгийн орлого оруулж, нийт 771143,7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 743060,6 мянган төгрөгийг зарцуулж 27167,5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 743060,6 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 12221,2 мянга, НДШ-н зардлыг 3260,0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 2246,2 мянга, хангамж бараа материалын зардлыг 96,3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 713,8 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 2022,3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71801 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 18542,6 мянга, 80805 арга хэмжээ 6602,6 мянга, 80101 арга хэмжээ 2022,3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийн бүлэгтэй тайлан:

Хүснэгт-2 төгрөгөөр

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **ХӨТӨЛБӨР 71701 Биеийн тамир спорт** | **770,228,200.00** | **743,060,617.00** | **27,167,583.00** | **96.47** |
| **АРГА ХЭМЖЭЭ 80101 Үндсэн үйл ажиллагааны** | **729,126,700.00** | **710,584,094.00** | **18,542,606.00** | **97.46** |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **729,126,700.00** | **710,584,094.00** | **18,542,606.00** | **97.46** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **729,126,700.00** | **710,584,094.00** | **18,542,606.00** | **97.46** |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 251,627,500.00 | 239,406,279.10 | 12,221,220.90 | **95.14** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,969,800.00 | 30,709,482.90 | 3,260,317.10 | **90.40** |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 393,907,600.00 | 391,661,317.00 | 2,246,283.00 | **99.43** |
| Хангамж, бараа материалын зардал | 9,110,000.00 | 9,013,062.00 | 96,938.00 | **98.94** |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 31,705,000.00 | 31,705,000.00 | 0.00 | **100.00** |
| Томилолт, зочны зардал | 500,000.00 | 496,000.00 | 4,000.00 | **99.20** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,306,800.00 | 7,592,953.00 | 713,847.00 | **91.41** |
| **ХӨТӨЛБӨР 71701 Биеийн тамир спорт** | **31,230,000.00** | **24,627,400.00** | **6,602,600.00** | **78.86** |
| **АРГА ХЭМЖЭЭ 80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн** | 31,230,000.00 | 24,627,400.00 | 6,602,600.00 | **78.86** |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **31,230,000.00** | **24,627,400.00** | **6,602,600.00** | **78.86** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **31,230,000.00** | **24,627,400.00** | **6,602,600.00** | **78.86** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 31,230,000.00 | 24,627,400.00 | 6,602,600.00 | **78.86** |
| **ХӨТӨЛБӨР 71701 Биеийн тамир спорт** | **9,871,500.00** | **7,849,123.00** | **2,022,377.00** | **79.51** |
| **АРГА ХЭМЖЭЭ 80802 Ажил олгогчоос олгох** | 9,871,500.00 | 7,849,123.00 | 2,022,377.00 | **79.51** |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,871,500.00** | **7,849,123.00** | **2,022,377.00** | **79.51** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **9,871,500.00** | **7,849,123.00** | **2,022,377.00** | **79.51** |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн | 8,371,500.00 | 6,349,123.00 | 2,022,377.00 | **75.84** |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | **100.00** |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 24250,9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, зарцуулж үндсэн үйл ажиллагааны орлогоос давсан 915,5 мянган төгрөгийг төвлөрүүлж зориулалтын дагуу 926,4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт:



005
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Хүснэгт-3 төгрөгөөр

| Гүйлгээний утга | Орлого | Зарлага |
|---|---|---|
| Аймгийн Засаг даргаас Орон сууцны дэмжлэг хөтөлбөрийн санхүүжилт | 5000000 | |
| Орон сууцны дэмжлэг | | 5000000 |
| Урд оны төвлөрүүлэлтийн орлого | 3630900 | |
| Ажлын хувцас | | 3600000 |
| Ариутгал халдваргүйжүүлэлт | | 20000 |
| ЗГХА БТСГ-с урамшуулалд | 500000 | |
| Урамшуулалд | | 500000 |
| Мэдээллийн цахим сан бүрдүүлэх зардал | 2000000 | |
| Мэдээллийн цахим сан бүрдүүлэх | | 2000000 |
| Цахим фитнес төслийн санхүүжилт | 13120000 | |
| Цахим фитнесийн тоног төхөөрөмж | | 13120000 |
| Төлөвлөгөө давж биелсэн орлого төвлөрүүлсэн | 915500 | |
| Үлдэгдэл төвлөрүүлэв. | | 926400 |
| Нийт дүн | 25166400 | 25166400 |

*Эх сурвалж: Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн данс*

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 127 мэдээллийг хугацаанд нь төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Хүснэгт-4*

| Д.Д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд нь байршуулсан | Хугацаа болоогүй | Хугацаа хоцроож байршуулсан | Үүнээс Хугацаа хоцроож байршуулсан: Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний | Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах | Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /мян.төг/ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Тоо | Тоо | Тоо | Тоо | Тоо | Тоо | Тоо | Орлого | Зарлага |
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 2 | 0 | | | | | | | | | |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | 0 | | | | | | | | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | | 1 | 1 | | | | | | | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 27 | | 9 | 3 | 0 | 6 | | | | | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 86 | | 10 | | 2 | | 3 | 2 | 1 | 2 | 103165.7 | 104057.7 |
| 6 | Нийт | 27 | 151 | 129 | 2 | 20 | 4 | 2 | 6 | 3 | 2 | 1 | 2 | 103165.7 | 104057.7 |

*Эх сурвалжийг: Тус байгууллагын шилэн дансны цахим сайтаас*

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөрчилд зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн биелэлтийг 202 оны 05 дугаар сарын 27 ний өдрийн 23 ний өдрийн 93 тоот албан бичгээр хариуг ирүүлсэн байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19760,2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2553,3 мянган төгрөгийн алдааг залруулж, 1876,9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 15330,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

## Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2018 онд бүртгэсэн 25350,0 мянган төгрөгийн дэвжээ, 2019 онд бүртгэсэн 1827,9 мянган төгрөгийн вакум хаалганы элэгдлийн зардлыг байгуулаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Элэгдэл байгуулаагүй 2 хөрөнгийн элэгдлийг байгуулж тайлант үеийн элэгдлийн зардалд 2553,3 мянган төгрөгийн элэгдлийг тооцуулж залруулга хийв.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1827,9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 2 албан шаардлага өглөө. Үүнд:

1. Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын дарга М.Мэнджаргалын 2019 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн Б/105 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн заалны зохион байгуулагч О.Загдсүрэнд Баянхонгор аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 08 ний өдрийн 131/ШШ2020/00463 тоот захирамжаар ажилгүй байсан хугацааны цалинд 1601864 төгрөгийг нөхөн олгох, НДШ-ыг тооцох шийдвэрийн дагуу Биеийн тамир спортын газрын цалингийн зардлаас 1601864 төгрөгийг олгож нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас ажилгүй байсан хугацааны НДШ-д 152177 мянган төгрөгийг төлж Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Зөрчил арилгах албан шаардлагыг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын даргад хүргүүлэв.

2. Сурын дасгалжуулагч Б.Мөнх-эрдэнэ 105,0 мянга, 2 багийн заал зохин байгуулагч Ж.Бөхбат 112,5 мянга, төгрөгийн цалинг нийгмийн даатгалд дутуу мэдээлсэн. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалт зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Дутуу мэдээлсэн 217,5 мянган төгрөгийг НДХ-т нөхөн мэдээлэх албан шаардлага өгөв.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 15330,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. **Балансын данстай холбоотой асуудал**

*1.1 <u>Илрүүлэлт:</u>* Тайлант онд Цахим фитнес төслийн санхүүжилт 13120,0 мянган төгрөг 2021.12.24 ний өдөр тухайн байгууллагын дансанд орж ирснээс шалтгаалж "Санко Маркетинг Монголиа" ХХК-аас "Ухаалаг самбар" 9990,0 мянга, "ОАЛ-селлер" ХХК-аас "Процессор МТ51-i5" 2410,0 мянга, "Хобби зоон" ХХК-аас "Гар утасны дүрс тогтворжуулагч" 480,0 мянган төгрөгөөр тус тус худалдан авахаар шилжүүлж авлагаар тусгасан, урсгал засварын зардлаас авто машины бэхэлгээ, нум хийлгэхээр Ерөөл нэмэх ХХК-д 2450,0 мянган төгрөгийг 2020.06.25 ний өдөр шилжүүлсэн боловч тухайн ажил хийгдээгүй авлага үүссэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*1.2 <u>Эрсдэл:</u>* Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Дансанд тусгасан авлагатай ААНБ-аас хөрөнгийг 2020.04.15 ний дотор хүлээн авч авлагыг бүрэн барагдуулан цаашид төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, өр авлага үүсгэхгүй ажиллах.

*1.3 <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар</u>:* Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## 2. *Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал*

*2.1 <u>Илрүүлэлт:</u>* Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээллээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 103165,7 мянган, зарлагын 104057,7 мянган төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

*2.2 <u>Эрсдэл:</u>* Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

*<u>Өгсөн зөвлөмж</u>:* Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллүүдээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, өөрчлөлт, хөрөнгийн зардал, төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, орон тоонд орсон өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг арилган, цаашид хуулийг хэрэгжүүлж ажиллах.

*<u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР — Г.ГАНЧИМЭГ
Огноо: 2021.02.23

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР — А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.23

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.23

6417143544
БНА0067 9007423



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/47/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газар | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Баянхонгор аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020.04.08 ний өдрийн 131/ШШ2020/00463 тоот захирамжаар ажилгүй байсан хугацааны цалинд О.Загдсүрэнд 1601864 төгрөгийг цалингийн зардлаас 1601864 төгрөгийг олгож нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас ажилгүй байсан хугацааны НДШ-д 152177 мянган төгрөгийг төлсөн. | 1,753.9 | Албан шаардлага өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | М.Мэнджаргал, Ч.Хандаа |
| 2 | Цахим фитнес төслийг хэрэгжүүлэхээр "Санко Маркетинг Монголиа" ХХК-аас "Ухаалаг самбар" 9990,0 мянга, "ОАЛ-селлер" ХХК-аас "Процессор МТ51-i5" 2410,0 мянга, "Хобби зоон" ХХК-аас "Гар утасны дүрс тогтворжуулагч" 480,0 мянган төгрөгөөр тус тус худалдан авахаар шилжүүлсэн авлага үүссэн, урсгал засварын зардлаас авто машины бэхэлгээ, нум хийлгэхээр "Ерөөл нэмэх" ХХК-д 2450,0 мянган төгрөгийг 2020.06.25 ний өдөр шилжүүлсэн боловч тухайн ажил хийгдээгүй авлага үүссэн | 15,330.0 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | М.Мэнджаргал, Ч.Хандаа |
| 3 | Сурын дасгалжуулагч Б.Мөнх-эрдэнэ 105,0 мянга, 2 багийн заал зохин байгуулагч Ж.Бөхбат 112,5 мянга, төгрөгийн цалинг нийгмийн даатгалд дутуу мэдээлсэн. | 123.0 | Албан шаардлага өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | М.Мэнджаргал, Ч.Хандаа |
| 4 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл 20 мэдээллийг хоцроож мэдээлсэн. | - | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | М.Мэнджаргал, Ч.Хандаа |
| 5 | Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 27177,9 мянган төгрөгийн хөрөнгийн 2553,3 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг байгуулаагүй байна. | 2,553.3 | Санхүүгийн тайланд залруулга хийх | Төсвийн захирагч, Нягтлан бодогч | М.Мэнджаргал, Ч.Хандаа |
| | ДҮН | 19760.2 | | | |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ